

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/17 дугаар удирдамжийн дагуу Улсын тэргүүний Хутаг-Өндөр сумын Улсын тэргүүний “Гацуурхан” цэцэрлэгийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2022 оны 09 сарын 29-ны өдрөөс хуанлын 7 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Хутаг-Өндөр сумын нэгдүгээр багт байршилтай 9013415 регистрийн дугаартай “Гацуурхан” цэцэрлэг нь эрхлэгч 1, арга зүйч 1, дуу хөгжмийн багш 1, эмч 1, үндсэн багш 10, туслах багш 10, явуулын багш 1, тогооч 5, гал тогооны туслах ажилтан 1, нягтлан бодогч 1, нярав 1, жижүүр 4, галч сахиул 5, үйлчлэгч 1 нийт 42 орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүргэсэн байна.

Тус сумын цэцэрлэгийн 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдөр хүртэлх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг С.Мөнхцэцэг, хоёрдугаар гарын үсгийг Д.Батчимэг нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100041315201 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041315404 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг Санхүүгийн тооцоолох “ACOLOUS” программаар бүртгэн хөтөлжээ.

Тайлант онд 03 сарын 01-ээс 03 сарын 26-ныг хүртэл 19 өдөр ажиллаж 4261 хүүхэд өдөрт 10,136.2 мянган төгрөгийн, 9 сарын 16-аас 09 сарын 30-ныг хүртэл 11 өдөр ажиллаж 716 хүүхэд өдөрт 1,720.1 мянган төгрөгийн, 10 сарын 01-ээс 10 сарын 29-нийг хүртэл 20 өдөр ажиллаж 1298 хүүхэд өдөрт 3,200.7 мянган төгрөгийн, 11 сарын 01-ээс

11 сарын 30-ныг хүртэл 20 өдөр ажиллаж 1901 хүүхэд өдөрт 4,382.7 мянган төгрөгийн, 12 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл 22 өдөр ажиллаж 1754 хүүхэд өдөрт 4,337.7 мянган төгрөгийн нийт 92 өдөр ажиллаж 9930 хүүхэд өдөрт 23,777.4 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулжээ. Хүснэгтээр харуулбал:

Цэцэрлэг	Бүлгийн тоо	3-р сар		9-р сар		10-р сар		11-р сар		12-р сар		Нийт дүн		
		Ажилласан өдөр	Хүүхэд өдрийн тоо	Ажилласан өдөр	Хүүхэд өдрийн тоо	Ажилласан өдөр	Хүүхэд өдрийн тоо	Ажилласан өдөр	Хүүхэд өдрийн тоо	Ажилласан өдөр	Хүүхэд өдрийн тоо	Ажилласан өдөр	Хүүхэд өдрийн тоо	Зарцуулсан материалын дүн /мян/төг/
Төв	5-6	19	3022	11	510	20	835	20	1386	22	1310	92	7063	17,221.9
Уньт	1	19	390	11	63	19	150	14	183	22	202	85	988	2,173.0
Хантай	1	19	472	11	86	20	174	20	190	22	147	92	1069	2,535.2
Хонгор	1	19	377	11	57	21	139	20	142	22	95	93	810	1,847.3
ДҮН	8-9	19	4261	11	716	20	1298	20	1901	22	1754		9930	23,777.4

Тус сумын “Гацуурхан” цэцэрлэгийн няраваар Х.Шижирбаатар, Уньт багийн цэцэрлэгийн няраваар туслах багш Н.Батжаргал, Хонгор багийн цэцэрлэгийн няраваар туслах багш Г.Одгэрэл, Хантай багийн цэцэрлэгийн няраваар туслах багш П.Урантогоо нар ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тус сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “**ЗӨРЧИЛГҮЙ**” санал дүгнэлт өгсөн байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд 2021 онд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 160 мэдээллийг тогтоосон хугацаанд нь ил тод мэдээлж, байршуулсан бол 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2022 оны 1-8-р сард мэдээлбэл зохих 114 мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд мэдээлж, ил тод байршуулжээ.

ДОЛОО. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны үндсэн болон нэмэлт дансны харилцах, төвийн цэцэрлэгийн болон Хантай, Уньт, Хонгор багийн цэцэрлэгийн хүнс, бараа материалын баримтууд, төсвийн шууд захирагчийн гаргасан А, Б шийдвэр, 9 бүлгийн ирцийн бүртгэл, үндсэн хөрөнгийн тайлан, эд хөрөнгийн тооллогын бүртгэл, татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, санхүүгийн тайлан, төрийн аудитын газраас 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, хөдөлмөрийн дотоод журам, дотоод хяналтын тайлан зэрэг холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Д.Батчимэгийг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2021 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 643,875.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,901.8 мянган төгрөг нийт 694,777.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 643,875.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,478.2 мянган төгрөг, хүүхдийн хоолны үлдэгдэл хүнсний материалыг худалдан борлуулсан орлого 4,489.8 мянган төгрөг нийт 698,843.3 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэж, үйл ажиллагааны зардалд 654,419.8 мянган төгрөгийг зарцуулж, 44,423.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Дэлхий нийтэд Ковид 19 цар тахал гарч хөл хорио тогтоосноор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа түр зогссонтой холбоотойгоор илүү цагийн хөлс олгогдоогүй, хоолны зардал болон бусад төсөвт зардал хэмнэгдэхэд нөлөөлсөн байна.

Цэцэрлэгийн харъяаны ахмад багш, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2020 онд ахмадын сан байгуулж, ахмадын сангийн 100041315501 дугаар дансанд оны эцэст 210.0 мянган төгрөг үлдсэн. Үүнийг 2021 онд сар шинийн баяр болон ахмадын баярыг тохиолдуулан ахмад багш, ажилтан нарт хүндэтгэл үзүүлэхэд зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт +, Хэтрэлт-	Төсвийн нийт зардалд эзлэх хувь
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	490,082.1	481,124.8	+8,957.3	73.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,251.1	62,277.0	+3,974.1	9.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,701.8	49,278.3	+423.5	7.5
2104	Хангамж, бараа материалын зардал	25,179.8	25,024.4	+155.4	3.8
2105	Нормативт зардал	49,343.2	22,653.2	+26,690.0	3.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,200.0	5,200.0	-	0.8
2107	Томилолт, зочны зардал	258.9	193.2	+65.7	0.03
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,403.6	1,388.2	+15.4	0.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,456.6	6,386.9	+69.7	0.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	900.0	894.0	+6.0	0.02
	Дүн	694,777.1	654,420.0	+40,357.1	100

Цалин хөлс, үр дүнгийн урамшууллын талаар:

Эрхлэгч С.Мөнхцэцэгт Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны Б/21, Б/24 дугаар захирамжаар ковидын нөхцөл байдлын үед 2020-2021 оны хичээлийн жилд эрхэлсэн ажлаа хангалттай сайн биелүүлэн ажилласан гэж 01-06, 09-12-р саруудад үндсэн цалингийн 25%-иар 2,412.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, сумын Засаг даргын 2021 оны Б/06, Б/20, Б/25, Б/29 дугаар захирамжийг үндэслэн 1-4-р

улиралд үндсэн цалингийн 15%-45%-иар 1,447.3 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт цалин тус тус олгосон байна.

Байгууллагын даргын тушаалыг үндэслэн 1-р улиралд 41 албан хаагчид 15%-60%-иар 13,501.5 мянган төгрөг, 2-р улиралд 42 албан хаагчид 22%-47%-иар 11,105.2 мянган төгрөг, 3-р улиралд 40 албан хаагчид 15%-45%-иар 8,052.8 мянган төгрөг, 4-р улиралд 18 хүнд 15%-60%-иар 14,358.9 мянган төгрөг **нийт 47,018.4 мянган төгрөгийн** үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

Мөн цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалыг үндэслэн 24 албан хаагчид 6,780.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгосон байна. Үүнд: Сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтны дунд жил бүр зохион байгуулагддаг 54 дэх удаагийн эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх “Илтгэл”-ийн уралдааны эхний шатанд амжилттай оролцож байр эзэлсэн 10 багшид 1-р сард үндсэн цалингийн 5-20%-иар 1,140.3 мянган төгрөг, Цар тахлын үед ажиллах чиглэлийг амжилттай хэрэгжүүлж эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэж идэвхи санаачлагатай ажилласан гэж арга зүйч Р.Оюумаад 1-6, 9-12-р сард үндсэн цалингийн 25%-иар 2,041.7 мянган төгрөг, 2020 онд эрхэлсэн ажлаа тогтмол сайн гүйцэтгэж, санхүүгийн тайлангаа хугацаанд нь чанартай гарган аудитаар зөрчил дутагдалгүй ажилласанд ня-бо Д.Батчимэгт 1-12-р сард үндсэн цалингийн 25%-иар 2,205.7 мянган төгрөг, 2021-2022 оны хичээлийн жилийн эхний хагас жилд эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэж идэвхи санаачлагатай ажиллаж, байгууллага, сум, бүс, аймгийн түвшинд амжилт гаргасан, хийж гүйцэтгэсэн ажлын үнэлгээгээр 85%-иас дээш үнэлэгдсэн дуу хөгжмийн багш, 4 багш, 3 туслах багш нийт 8 багшид 12-р сард үндсэн цалингийн 10-20%-иар 943.3 мянган төгрөг, эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол үр бүтээлтэй гүйцэтгэж бусдаасаа илүү идэвхи санаачлагатай ажилласан тогооч, 3 жижүүрт 12-р сард үндсэн цалингийн 15-25%-иар 449.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

2021 онд ажлаараа бусдыгаа хошуучлан манлайлж байгууллагын аварга болсон “Аварга багш” Л.Гэрэлцэцэг, “Аварга тогооч” П.Оюунцэцэг нарыг үндсэн цалингийн 50%-иар 676.4 мянган төгрөгөөр, “Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх жил”-ийн ажлын хүрээнд байгууллагын албан хаагчдад монгол бичгийг амжилттай заан сургаж, сумын төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан монгол бичгийн уралдаанд 2-р байр эзэлсэн багш Б.Сувд-Эрдэнэ, туслах багш Л.Пүрэвдэлгэр, ня-бо Д.Батчимэг нарыг үндсэн цалингийн 15-20%-иар 373.9 мянган төгрөгөөр тус тус шагнасан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оныг “Бүтээмж чанарыг сайжруулах жил” болгон зарласан ажлын хүрээнд анги бүлэгтээ бүтээмжийг амжилттай хэрэгжүүлсэн Бэлтгэл А, Б, В, Ахлах А, Хонгор баг нийт 5 бүлгийг 390.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулжээ.

Албан хаагчдын цалин хөлснөөс цалингийн урьдчилгаанд олгосон 18,070.0 мянган төгрөг, хамтын сангийн 17,813.8 мянган төгрөг, жимобайлын утасны төлбөрийн 6,046.0 мянган төгрөгийг суутгасан байна.

Нэмэлт төсөө: Тайлант онд аймгийн БСУГазраас /хуучин нэрээр/ ариутгал халдваргүйжүүлэлтийн 260.0 мянган төгрөг, “Ногоон оффис” шалгаруулах уралдааны дэд байрын шагналын мөнгө 360.0 мянган төгрөг, “Эко цэцэрлэг” шалгаруулах болзолт уралдааны дэд байрын шагналын мөнгө 360.0 мянган төгрөг, Хүнсний бүтээгдэхүүн

нийлүүлэх тендерийн материал худалдан авах үнэ (Цагаан булан түүчээ ХХК, АОСО ХХК, Намнангийн хишиг ХХК) 60.0 мянган төгрөг нийт 1,040.0 мянган төгрөгийн орлого орсон.

Үүнээс “Хутаг тэмүүлэл” эргэлтийн эмийн сангаас 260.0 мянган төгрөгөөр зайнаас халуун хэмжигч 1 ширхэг, нэг удаагийн халад 10 ширхэг, нэг удаагийн бээлий 1 хайрцаг, Тоймаагаас 60.0 мянган төгрөгөөр нүхтэй уут 2 боодол, бичгийн цаас 2 боодол, “Ногоон оффис” уралдааны шагналын мөнгөөр БЧАТГ ХХК-иас 66.1 мянган төгрөгөөр цэцгийн үр, 50.0 мянган төгрөгөөр газрын алимны үрсэлгээ 10 ширхэг, 80.0 мянган төгрөгөөр цэцгийн сав 8 ширхэг, Соёолж ХХК-иас 68.5 мянган төгрөгөөр бороожуулагч /зүлэг услагч/, 32.9 мянган төгрөгөөр зүлэгний үр, Д.Батчимэгээс 62.5 мянган төгрөгөөр цэцгийн үрсэлгээ, “Эко цэцэрлэг” шалгаруулах уралдааны шагналын мөнгөөр БЧАТГ ХХК-иас 300.0 мянган төгрөгөөр 5 ширхэг акустик хавтан, 60.0 мянган төгрөгөөр хуулга, даалимба, эсгий, гэрэл тус тус авч, Хүүхэд хөгжлийн төвд болон байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Дотоод хяналт шалгалтаар: Няравын агуулахын бүртгэл хөтлөлт, агуулахын эмх цэгц, тайлан гаргалт, шинээр ирсэн үндсэн хөрөнгийг тухай бүрд нь эзэнжүүлсэн байдал, албан хаагчдад шаардлагатай бараа материалыг тухай бүр нь худалдан авч олгосон байдал зэрэг чиглэлээр шалгаж, үнэлгээ өгсөн байна. Уг шалгалтаар агуулах бүртгэл хөтлөлт 10 оноо авахаас 0 оноо, тайланг сар бүрийн 08-ны дотор нягтлан бодогчид өгдөг эсэх 10 онооноос 5 оноо, агуулахын үлдэгдлийг улирал бүр тоолуулдаг эсэх 10 онооноос 5 оноо, шинээр ирсэн үндсэн хөрөнгийг тухай бүрд нь эзэнжүүлсэн байдал 10 онооноос 5 оноо өгсөн бол агуулахын эмх цэгц, тогооч нарт хүнсний материал, албан хаагч нарт шаардлагатай бараа материалыг цаг тухай бүрд нь тавьж олгосон эсэх зэрэгт авах ёстой 10 оноог бүрэн өгч, үнэлсэн байна.

Гэвч дотоод хяналт шалгалт хийсэн дүнг нэгтгэж гаргаагүй, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг хэзээ, хэрхэн арилгах тодорхойгүй байна.

7.2 Өглөг, авлагын талаар:

Тайлант онд өглөггүй. Авлагын хувьд; 2021 оны эхэнд 15,360.0 мянган төгрөгийн авлагатай байснаас 7,760.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, байгууллагаас авах 7,600.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлан баланс гаргасан байна.

Үүнд: 2020 онд цэцэрлэгийн нэмэлт төсвийн дансанд орсон “Эко цэцэрлэг” шалгаруулах болзолт уралдааны дэд байрын шагналын 360.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнийг тайлант онд буцаан олгосон. Улаанбаатар хотын Битаачи ХХК, “Номин ногоон тал” ХХК 2 компаниас хүүхдийн сургалтанд хэрэглэгдэх 15,000.0 мянган төгрөгийн тоглоом авахаас 2021 оны 06-р сарын 20-нд Битаачи ХХК-иас 10 нэр төрлийн 113 ширхэг 1,899.0 мянган төгрөгийн, “Номин ногоон тал” ХХК-иас 9 нэр төрлийн 75 ширхэг 5,501.0 мянган төгрөгийн нийт **19 нэр төрлийн 188 ширхэг 7,400.0 мянган төгрөгийн** тоглоом авч, 7,600.0 мянган төгрөгийн тоглоом аваагүй байна.

7.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж,	714,327,275.20	33,320,720.00	0.00	747,647,995.20

	орон сууц				
2	Машин тоног төхөөрөмж	36,780,705.00	39,962,681.55	749,900.00	75,993,486.55
3	Тавилга, эд хогшил	49,978,851.95	14,446,500.00	17,829,781.75	46,595,570.20
4	Номын фонд	1,436,817.39	94,000.00	0.00	1,530,817.39
5	Бусад үндсэн хөрөнгө	95,141,029.30	10,613,030.00	37,798,219.80	67,955,839.50
6	Программ хангамж	880,000.00	0.00	0.00	880,000.00
7	Бусад биет бус хөрөнгө	29,100,000.00	0.00	0.00	29,100,000.00
	Дүн	927,644,678.84	98,436,931.55	56,377,901.55	969,703,708.84

Нийт 24,057.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн. Үүнд:

Тусгалын өндөр ХХК-иас 13,000.0 мянган төгрөгөөр 100 ширхэг хүүхдийн ор, Чиглэл тоног төхөөрөмж ХХК-иас 2,750.0 мянган төгрөгөөр нэгдүгээр хоолны тогоо, Хос задь ХХК-иас 1,900.0 мянган төгрөгөөр Epson L1800 маркийн принтер, Мээж хайрхан тулга ХХК-иас 663.0 мянган төгрөгөөр 3 ширхэг сандал, Сунтхөгжил БГБХНөхөрлөлөөс 930.0 мянган төгрөгөөр Canon G4010 загварын өнгөт принтер, 2,125.0 мянган төгрөгөөр Canon EOS 1500D загварын зургийн аппарат, 1,945.0 мянган төгрөгөөр проектор, Гүрсоронзон ХХК-иас 650.0 мянган төгрөгөөр хөлдөөгч, Монгол шуудан ХХК-иас 24.0 мянган төгрөгөөр “Боловсрол судлал” ном, Тоймаагаас 70.0 мянган төгрөгөөр 3 нэр төрлийн 3 ширхэг ном худалдан авсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 12,000.0 мянган төгрөгөөр Уньт багийн зуны нүүдлийн цэцэрлэгийн барилгын гадна талын дулаалгын их засварын ажлыг, урьд онд бэлтгэсэн хөрөнгийн эх үүсвэр 7,000.0 мянган төгрөгөөр Тээл багийн зуны нүүдлийн цэцэрлэгийн барилгыг тус тус аж ахуйн аргаар гүйцэтгэн ашиглалтад хүлээн авч барилга байгууламжийн дансанд бүртгэсэн байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 09 сарын 01-ний өдрийн А/16 дугаар тушаалаар Төсвийн тухай хуулийн 16.5.5, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11.1.1, Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01-р сарын 23-ны өдрийн 17 дугаар тогтоолын 6.1, 6.2 дахь заалтуудыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 01-р сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулахтай холбогдуулан нийт 99 нэр төрлийн 64,359.9 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг данс хооронд нь шилжүүлж бүртгэсэн байна. **Үүнд:**

--- Тавилга эд хогшил данснаас бусад үндсэн хөрөнгө, машин тоног төхөөрөмжийн дансанд 30 нэр төрлийн 17,829.8 мянган төгрөгийн хөрөнгө

--- Машин тоног төхөөрөмжийн данснаас бусад үндсэн хөрөнгийн дансанд 1 нэр төрлийн 749.9 мянган төгрөгийн хөрөнгө

--- Бусад үндсэн хөрөнгийн данснаас барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, аж ахуйн материалын дансанд 42 нэр төрлийн 37,798.2 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материал

--- Аж ахуйн материалын данснаас тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн дансанд 26 нэр төрлийн 7,982.0 мянган төгрөгийн хөрөнгө.

7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	293,000.00	1,727,800.00	1,710,800.00	310,000.00

2	Аж ахуйн материал	22,123,149.75	20,208,390.00	33,351,539.75	8,980,000.00
3	Түлш, шатах тослох	2,367,500.00	6,294,200.00	5,313,575.00	3,348,125.00
4	Хоол, хүнс	11,116,826.00	22,351,475.50	29,324,282.15	4,144,019.35
5	Барилга засвар	4,817,000.00	1,485,600.00	6,302,600.00	0.00
6	Эм боох материал	0.00	21,350.00	21,350.00	0.00
7	Бусад хангамж	2,558,000.00	6,052,750.00	8,610,750.00	0.00
	Дүн	43,275,475.75	58,141,565.00	84,634,896.90	16,782,144.35

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 38,978.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 45,673.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 09 сарын 01-ний өдрийн А/16 дугаар тушаалаар бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан 8,980.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэлийг /25.0 мянган төгрөгийн нэгжийн үнэтэй хөнжил 100 ширхэг, 28.0 мянган төгрөгийн нэгжийн үнэтэй гудас 100 ширхэг, 23.0 мянган төгрөгийн нэгжийн үнэтэй цагаан хэрэглэл 160 ширхэг/ аж ахуйн материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 09 сарын 01-ний өдрийн А/15 дугаар тушаалаар ашиглалтын шаардлага хангахгүй, эвдэрч хэмхэрсэн, ашиглах хугацаа нь дууссан 9 нэр төрлийн 102 ширхэг 2,407.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө /аж ахуйн материал/-ийг акталж, данс бүртгэлээс хассан.

БШУЯамны хөрөнгө оруулалтын газраас 1,541.0 мянган төгрөгийн 17 нэр төрлийн хөгжмийн хэрэгсэл, 123.7 мянган төгрөгийн тусгаарлах өрөөний багц, Жайка ОУБ-с 30.0 мянган төгрөгийн үнэтэй автомас 1 ширхэг, 43.6 мянган төгрөгийн ариутгалын бодис 4 ширхэг нийт 1,738.3 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүйгээр өгсөн.

Коронавирус /ковид-19/ халдварт цар тахал өвчин гарч улсын хэмжээнд хөл хорионы дэглэм тогтоож сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа 2021 оны 03-р сарын 31-ний өдрөөс зогссонтой холбоотойгоор цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 04-р сарын 26-ны өдрийн А/10 дугаар тушаалыг үндэслэн хүүхдийн хүнсний хэрэгцээнд бэлтгээд зарцуулагдаагүй үлдсэн **79 нэр төрлийн 6,584.4 мянган төгрөгийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 64 нэр төрлийн 4,489.9 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг** дансны үнээр худалдан борлуулж, хүнсний материалын үнэ 4,489.8 мянган төгрөгийг байгууллагын үндсэн дансанд шилжүүлсэн, **15 нэр төрлийн 2,094.5 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг** бэлтгэн нийлүүлэгч дэлгүүр болон төсөвт байгууллагад буцаан авахаар өгч, бүрэн авсан байна. **Үүнд:** 13 нэр төрлийн 904.5 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгч дэлгүүр болох Мээж хайрхан тулга ХХК-д намар хичээлийн жил эхлэхэд авахаар өгч 9-р сард буцаан авсан, 2021 оны 03 сарын 02-нд Хонгор багийн цэцэрлэгээс төвийн цэцэрлэгт **1,050.0 мянган төгрөгийн 140 кг мах** өгснийг төвийн цэцэрлэг 3-р сард орлогод авч хүүхдийн хоолонд зарцуулсан, Хантай багийн цэцэрлэгээс сумын сургуульд **140.0 мянган төгрөгийн 200 кг төмс** өгсөнийг нярав Шижирбаатар 2021 оны 12 сарын 01-нд П.Урантогоогоос 200 кг төмс авсанаар орлогодсон байна.

Хүснэгтээр харуулбал:

Цэцэрлэг	Үлдэгдэл хүнсний материалын дүн	Үүнээс		Тайлбар /худалдсан/
		Худалдан борлуулсан хүнсний материал	Буцаан авахаар өгсөн хүнсний материал	

		Нэр төрөл	Мөнгөн дүн	Нэр төрөл	Мөнгөн дүн	Бэлтгэн нийлүүлэгч, байгууллагын нэр	
Төв	1,521,260.30	16	616,746.00	13	904,513.50	Мээж хайрхан тулга ХХК	Мээж хайрхан тулга ХХК
Хантай баг	1,343,802.30	8	1,203,802.30	1	140,000.00	Сумын Сургуульд	ЭМТөв, Сургуульд, М.Ганхуяг, Мягмардэлгэр, Нармандах, Урангоо нарт
Хонгор баг	2,203,285.40	19	1,153,285.40	1 /max/	1,050,000.00	Төв цэцэрлэгт	
Уньт баг	1,516,020.00	21	1,516,020.00	0	0	0	Сумын ЭМТөв, АОСО ХХК-д худалдсан
ДҮН	6,584,368.00	64	4,489,853.70	15	2,094,513.50		

2021 оны 08-р сард аймгийн Төрийн аудитын газраас хийсэн явцын аудитаар “Бараа материалын дансанд ашиглаж байгаа бараа материалыг НББОУС-ын дагуу данс бүртгэлээс хасах” зөвлөсний дагуу гэж байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй 23,037.6 мянган төгрөгийн бараа материалыг актлан, данс бүртгэлээс хассан байна.

ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Улсын тэргүүний “Гацуурхан” цэцэрлэг нь 2021 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн хүрээнд Боловсролын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газраас хамтран зохион байгуулсан “Эко цэцэрлэг” шалгаруулах болзолт уралдаанд “**Дэд байр**”, Бүтээмж – чанарыг сайжруулах жилийн аяны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газраас хамтран зохион байгуулсан “Ногоон оффис” болзолт уралдаанд мөн “**Дэд байр**” эзэлж, мөнгөн шагналаар шагнуулсан байна.

Санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагаар хянуулан баталгаажуулсан, төсвийн хөрөнгөөр болон хандив, тусламж, үнэ төлбөргүйгээр ирсэн хөрөнгийг орлогод авч, данс бүртгэлд тусгасан, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлэн актаар баталгаажуулсан, эд хариуцагч бүртэй хөрөнгө, бараа материалын тооцоог бодож хэвшсэн, өмнө хийгдсэн шалгалтаар шаардах хуудсаар зарцуулсан бараа материалд зарлагын баримт үйлддэггүй байсан зөрчлийг арилгасан, харилцахын болон аж ахуйн баримт материалыг эмх цэгцтэй үдэж архивласан зэрэг дэвшилттэй байна.

ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

Агуулахын бүртгэл шалгуулаагүй, тооллогын комисс хөрөнгө, бараа материалын данс бүрээр тооллогын бүртгэл хөтөлсөн байгаа ч эд хөрөнгийн тооллогын бүртгэлд хөрөнгө, бараа материалын нэгжийн үнийг тавиагүй, нийт дүнг дүгнээгүй, ажилтан албан хаагчдын эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг эхний хагас жилд хөтлөөгүй, жилийн

эцэст хөтөлсөн ашиглалтын бүртгэлд эзэмшигчийн гарын үсэг зурагдаагүй, Хантай, Хонгор багийн цэцэрлэг хоолны өдөрлөгт хэмжих нэгж бичээгүй, Уньт багийн цэцэрлэг хоолны өдөрлөгийн нийт дүнг харандаагаар бичсэн, төвийн болон багийн 3 цэцэрлэг шаардах хуудаст хэнээс гэдэгт няравын нэрийг бичиж буруу хөтөлсөн, шаардах хуудас, зарлагын баримтыг дугаарлаагүй, орлогын баримтыг нэг хувь үйлддэг, шилэн дансны нэгдсэн сайтад 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлага үйлдэв.

Байгууллагын нягтлан бодогчид эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд эзэмшигчийн гарын үсгийг хөрөнгө тус бүрээр зуруулах, тооллогын бүртгэлд хөрөнгө материалын нэгжийн үнийг бичүүлж, нийт дүнг дүгнүүлэх, агуулахын бүртгэлийг өдөр тутам хөтлүүлэх, багийн цэцэрлэгийн хоолны өдөрлөгийг засваргүй үйлдүүлж байх зэрэг асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ДҮГНЭЛТ

Тус сумын цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримтууд эмх цэгцтэй, анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай байна.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, төлбөрийн актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.БАТТУЛГА

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Ж.ОЮУН

